



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБА

18072 Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг,
29 дүгээр хороо, Үйлдвэрчний эвлэлийн гудамж 37,
Утас: 7018 1208, 7018 1447 7018 1206

И-мэйл: info@ngs.gov.mn, Вэбсайт: www.ngs.gov.mn

2026.06.18 № 1/420

танай _____-ны № _____-т

**АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС
БАЯЛГИЙН ЯАМАНД**

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Үндэсний геологийн албаны 2026 онд хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн эхний хагас жилийн тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт хуудастай.

**ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ**

Н.МӨНХБИЛЭГ

23 105 319

№	ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНД 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР ХАРИУЦАН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ИРҮҮЛСЭН ДЭЭД ГАЗРУУДЫН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ											
	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Шийдвэр ийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Биелэлт	Хэрэгжсэн	Үнэлгээ /Шалтгаан/				Хугацаа болоогүй	Хэрэгж их болом жгүй	Хяналтаас хасуулах тухай санал /хүчингүй болсон эсэх/
						Хэрэгжих шатанд		Хэрэгжээгүй				
						Тодорхой үр дүнд хүрсэн	Удаашралтай/ эрчимжүүлэх шаардлагатай	Зохион байгуулалт аас	Хөрөнгө дутагдса наас			
Засгийн газрын тогтоол												
1	Ажил, амралтын цагийг зохицуулах тухай, /2026.01.21/	22	1	Үндэсний геологийн албаны даргын 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/07 дугаар тушаалаар Монгол үндэстний уламжлалт баяр-Цагаан сарын битүүний өдөр иргэдийн ажил, амралтыг зохицуулах зорилгоор 2026 оны 02 дугаар сарын 17-ны мягмар гарагийн ажлын өдрийг 2026 оны 02 дугаар сарын 28-ны бямба гарагийн амралтын өдөрт шилжүүлсэн.	тийм	+	-	-	-	-	-	-
2	Журам шинэчлэн батлах тухай, Цахим хуудас хөтлөх, ил тод, нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам. /2026.02.04/	41	2	Тус журмын дагуу албаны даргын 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/20 дугаар тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн дотоод журамд тусгагдсан албаны нэгдсэн веб сайтыг хөтлөн явуулах бөгөөд, төрийн байгууллагын нэгдсэн веб сайтад хандах эрх бүхий админ, мэдээлэл оруулах үүрэг бүхий албан хаагчдыг томилох. Цахим хуудас хөтлөх, ил тод, нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих үүрэг бүхий албан хаагчийг 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн Б/17 дугаар тушаалаар томилсон.	тийм	+	-	-	-	-	-	-
3	"Ерөнхий төлөвлөгөө батлах тухай", НҮБ-ын хүний эрхийн зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмжүүдийг 2026-2030 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө. /2026.03.11/	73	2	Үндэсний геологийн алба нь зохион байгуулалтын 6 нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд удирдах түвшний албан тушаал эрхэлж буй албан хаагчдын 50 хувийг эмэгтэй албан хаагчид бүрдүүлж байна. Засгийн газрын 2025 оны 52 дугаар тогтоолоор Үндэсний геологийн албаны орон тооны дээд хязгаарыг 32 байхаар баталсан. 2026 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн Б/12 дугаар тушаалаар байгууллагын бүтэц шинэчлэгдсэнтэй холбогдуулан албан хаагчдыг томилсон. 2026 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар байгууллагын хэмжээнд төрийн захиргааны албан тушаалын 6 сул орон тоо байна. Үүнтэй холбоотойгоор удирдах албан тушаалын болон байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зайлшгүй шаардлагатай сул орон тоог нөхөн бүрдүүлэх зорилгоор сонгон шалгаруулалт зарлуулах хүсэлтийг 2026 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 1/305 дугаартай албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны дэргэдэх салбар зөвлөлд хүргүүлсэн. Мөн Үндэсний геологийн албаны хамт олон Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аянд нэгдэж, тус аяны зорилго, ач холбогдлын талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэсэн.	тийм	+	-	-	-	-	-	-

4	“Төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, төрийн албан хаагчдын ажлын ачааллыг бууруулах	119	4	Төрийн албан хаагчийг долоо хоногийн нэг өдөр зайнаас цахим сүлжээгээр ажиллуулах, ажлын цагийг уян хатан байх тухай 4дүгээр заалтын хүрээнд албаны даргын 2026 оны 04 дүгээр сарын 20-ны А/24 дугаартай "Зайнаас цахимаар ажиллуулах тухай" тушаал батлагдаж мөрдлөг болгон ажиллаж байна.	тийм	+	-	-	-	-	-	-
5	Улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай, /2026.04.15/	129	1.8	Төрийн албаны зөвлөлийн 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 06/631 дугаартай албан бичгээр “Зөвшөөрөл олгох тухай” 126, 127, 128 дугаар тогтоол ирсэн. Тогтоолын дагуу төрийн захиргааны 14 албан хаагч, төрийн үйлчилгээний 17 ажилтны албан тушаалын тодорхойлолтыг албаны даргын 2026 оны А/16, А/17, А/18, А/19 дугаар тушаалаар баталсан. Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн хүрээнд заасан удирдамж, жагсаалтын дагуу холбогдох баримт материал, мэдээллийг бэлтгэн танилцуулсан. Үзлэгийн дүнгээр байгууллага 87 хувийн үнэлгээ авсан.	тийм	+	-	-	-	-	-	-
Хэсгийн дундаж:					100 Хувь							
Ерөнхий сайдын захирамж												
6	Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай, /2026.04.29/	94	1	Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 94 дүгээр захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, санал, дүгнэлт, төсөл боловсруулж танилцуулах үүрэг бүхий Геологи, уул уурхайн асуудал хариуцсан Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Мөнхбилэг орж холбогдох мэдээллээр ханган ажилласан.	тийм	-	+	-	-	-	-	-
Хэсгийн дундаж:					100 Хувь							
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл												
7	Засгийн газрын 2025 оны үйл ажиллагааны тайлан, төрийн захиргааны байгууллагын болон албан хаагчийн 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулалтын явцын талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт Засгийн газрын гишүүдэд танилцуулав. /2026.01.14/	2	1,2,3,4,5	Үндэсний геологийн албаны 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан Бодлогын баримт бичигт Үндэсний геологийн албаны хариуцан гүйцэтгэхээр тусгасан арга хэмжээ, “Албаны 2025-2029 оны Стратеги төлөвлөгөө”-тэй уялдуулан геологи, хайгуулын салбарын судалгаа, хөгжлийн суурь түвшнийг харгалзан, албаны чиг үүрэгтэй нийцүүлэн 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам", Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын "Аргачлал, загвар батлах тухай" 2020 оны 100 дугаар тушаалын 3, 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал, загвар”-т үндэслэн 2026 оны шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг тодорхойлж, хүлээгдэж буй гүйцэтгэл, үр дүнг тооцож, боловсруулан Төсвийн шууд захирагчийн 2026 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2026 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн 1/34 дугаартай албан бичгээр Төсвийн ерөнхийлөн захирагчаар хянуулж, батлуулахаар хүргүүлсэн. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас 2026 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 03/305 дугаартай албан бичгээр санал ирүүлсэн. Тус саналыг тусган 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 1/98 дугаартай албан бичгээр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд хүргүүлсэн. Төсвийн шууд захирагчийн 2026 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг Төсвийн ерөнхийлөн захирагч 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдөр баталсан.	тийм	+	-	-	-	-	-	-

8	"Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2025 оны гүйцэтгэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр Засгийн газрын гишүүдэд танилцуулав, /2026.01.28/	4	4	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг дараах байдлаар эрчимжүүлэн ажиллаж байна. 2026 оны хувьд Үндэсний геологийн алба нь 1:50000-ны геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын Хэцүү уул-50, Алтан ширээ уул-50, Төхөлийн элс-50, Цахирын хяр-50, 1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглалын ажлын Хархорин-25 төслүүдийн геологийн даалгаврыг боловсруулан, батлуулж, геологи судалгааны ажлууд, "Монгол Улсын өмнөд хил орчмын нутгийн геологи, геохимийн зураг зохиох судалгааны ажил", "Монгол Улсын хойд хил орчмын нутгийн геологи, геохимийн зураг зохиох судалгааны ажил", Монгол улсын газар тариалангийн бүс нутгийн хөрсний геохими-эрдэслэг бүрлэдхүүн-гео-орчны судалгаа төслүүдийн геологийн даалгаврыг боловсруулан, батлуулж, геологи судалгааны ажлыг тус тус шинээр эхлүүлэн ажиллаж байна. Нэгдсэн геомэдээллийн санг шинээр тогтоогдсон 27 илрэл буюу Дөчгол-50 төслийн 10875 дугаартай тайлангаас 11 илрэл (Au-7, Mn-1, W-1, CaF2-2); Үнэгт уул-50 төслийн 10880 дугаартай тайлангаас 16 илрэл (Fe-1, Mn-2, As-1, CaF2-2, кварцит-1, өнгөлгөөний чулуу-7, тоосгоны шавар-2) илрэлийн мэдээллээр нэгдсэн цахим санг баяжуулсан. Ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлийг 35 ордын 36 нөөцийн мэдээллээр баяжуулав. Геохимийн мэдээллээр нэгдсэн цахим санг 600 өгөгдөл, мэдээллээр, Гидрогеологийн уст цэгийн 483 өгөгдөл, мэдээллээр, Чулуун дээжийн санг хувийн хөрөнгөөр хайгуул хийсэн судалгааны ажлуудын үр дүн болох 20000 шлиф, аншлиф, чөмгөн дээжийн мэдээллээр баяжуулсан. Өвөрхангай аймгийн Хархорин, Архангай аймгийн Хашаат, Өгийнуур сумдын нутагт 4014,11км2 талбайд 2026-2029 онд хэрэгжүүлэх 1:25000-ны масштабтай гео орчны судалгаа, эрлийн ажил "Хархорин-25" төслийн ажлын даалгаврыг боловсруулан 2026 оны 03 дугаар сарын 02-ны өдөр АҮЭБЯ-ны төрийн нарийн бичгийн даргаар батлуулан сонгон шалгаруулах тендерийг 2026 оны 03 дугаар сарын 13-ны өдөр зарласан. Уг төслийг хэрэгжүүлэгчтэй 2026 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр гэрээ байгуулан судалгааны ажлыг эхлүүлсэн.	тийм	+	-	-	-	-	-	-
9	Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 2025 оны жилийн эцсийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн дүнг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт Засгийн газрын гишүүдэд танилцуулав, /2026.02.25/	7	1.1, 1.2, 1.3,	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 183 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журмын биелэлтийг батлагдсан маягтын дагуу тайлагнасан.	тийм	+	-	-	-	-	-	-

10	Ойрх Дорнодын бүс нутагт үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан Монгол Улсын эдийн засагт учирч болзошгүй хямралыг хохирол багатай даван туулах, онцгой нөхцөл байдлын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөөний талаар Монгол Улсын Тэргүүн шадар сайд	11	1	2026 онд батлагдсан төсвийн хүрээнд зайлшгүй шаардлагатай урсгал зардлыг хуваарийн дагуу төлөвлөн, батлагдсан төсвийн хэмжээнд зарцуулж байна. 2026 оны шатахууны зардалд 2,140.8 мянган төгрөг ба сард 178.400 мянган төгрөг байна. Уг төсвийг байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа, дотоод хэрэгцээнд зарцуулдаг боловч бодит хэрэгцээг бүрэн хангахад хүрэлцэхгүй, шатахууны зардлын дутагдал үүссэн байна. ГСА-ын төсөл хэрэгжүүлж буй аж ахуйн нэгжүүдэд улсын төсвийн хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас санхүүжилт олголт хугацаандаа хийгдэхгүй, хоцрогдол үүсэж байгаа талаар тухай бүр мэдээлж, харилцан ойлголцлын үндсэн дээр хамтран ажиллаж байна.	тийм	+	-	-	-	-	-	-
11	2025 онд иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр Засгийн газрын гишүүдэд танилцуулав, /2026.05.06/	17	3	2026 онд эхний хагас жилийн хугацаанд манай байгууллагад гаднаас ирсэн өргөдөл, гомдол байхгүй. Иргэдийг хүлээн авч уулзах хуваарийг 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/59 дугаар тушаалаар баталж мөрдлөг болгон ажиллаж байна.	тийм	+	-	-	-	-	-	-
Хэсгийн дундаж:					100 Хувь							
Ерөнхий сайдын албан даалгавар												

12	Төрийн зарим үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх талаар авах зарим арга хэмжээний тухай. /2026.02.11/	2	1.1	Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа "чөлөөлье" аяны хүрээнд хийгдэж байгаа ажлууд: - Архив албан хэрэг хөтлөлтийг цахимжуулах ажлыг байгууллагын хэмжээнд бүрэн зохион байгуулж ажиллаж байна. Албан бичиг солилцооны дундын систем буюу досх, ер системд нэвтэрч, харилцагч ААН-үүдэд уг системээр албан бичиг солилцох тухай санал хүргүүлсэн. Төрийн байгууллагуудтай https://intranet.gov.mn/ эблэ системээр албан бичиг солилцоог бүрэн цахимжуулсан. - Үндэсний геологийн алба нь нийт 6 нэгжтэй бөгөөд үүнээс 5 нэгж нь Сонгинохайрхан дүүргийн 29 дүгээр хороонд байрлах 3 давхар төв байранд, Геологийн баримтын төв архив нь Чингэлтэй дүүргийн 5 дугаар хороонд байрлах Засгийн газрын XII байрны баруун жигүүрт түр байрлан үйл ажиллагаа явуулж байна. Аж ахуй нэг болон иргэдээс ирүүлэх албан бичиг, өргөдөлийг Геологийн баримтын төв архивд болон Үндэсний геологийн албаны төв байранд хүлээн авч байна. - Улсын төсвийн хөрөнгийн санхүүжилттэй төслүүдийн сар бүрийн гүйцэтгэлийн тайланг цаасаар авдаг байсныг цахимжуулах зорилгоор 2026 оны эхнээс холбогдох системийн хөгжүүлэлтийг хийж эхэлсэн. Энэ оны сүүлийн хагас жилээс гүйцэтгэлийн санхүүжилтийн мэдээг ААН-үүдээс цахимаар хүлээн авдаг болхоор ажиллаж байна.	тийм	+	-	-	-	-	-	-
Хэсгийн дундаж:					100 Хувь							
Монгол Улсын хууль												
13	Төрийн албаны тухай хууль, /2017.12.07/	-	55.3	Үндэсний геологийн албаны даргын 2026 оны А/06 дугаар тушаалаар 2026 онд хэрэгжүүлэх "Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах болон сургалтын төлөвлөгөө"-г баталсан. Төлөвлөгөөний дагуу: Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 226 дугаар тогтоолоор "Төрийн жинхэнэ албаны зарим тушаалын цалингийн хэмжээг" шинэчлэн тогтоосон ба тус тогтоолыг 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Тогтоолын дагуу холбогдох албан хаагчдын цалингийн хэмжээг УГА-ны даргын 2026 оны А/05 дугаар тушаалаар батлуулан, мөрдөж байна. Төрийн үйлчилгээний албан хаагчдад олгох үр чадварын нэмэгдлийг холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн баримт бичгийг үндэслэн сар бүр Үндэсний геологийн албаны даргын тушаалаар олгож байна. Албан хаагчдын ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зардалд өдөр бүр 3.0 мянган төгрөг, хоолны зардлыг өдөр бүр 32.0 мянган төгрөгөөр тооцон олгож байна. Сургалтын төлөвлөгөөний дагуу: Албан хаагчдын мэргэжил, үр чадварыг дээшлүүлэх мэргэшсэн болон зөвлөх геологичийн сургалтад 5 албан хаагч хамрагдаж төгссөн. Мөн Удирдлагын академийн төрийн албанд томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 2 албан хаагч, ахлах түшмэлийн багц сургалтад 1 албан хаагч хамрагдаж байна.	тийм	+	-	-	-	-	-	-
Хэсгийн дундаж:					100 Хувь							
Нийт дундаж:					100 Хувь							